ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДАА-2024/02/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Дархан-Уул аймаг<br>2023 он | Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр<br>Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br>Аудитор: Н.Отгонцэцэг<br>Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**


ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дархан-Уул аймаг 45059
Утас: 7037-3289, Факс: (976) 7037-3289
Цахим хуудас: www.audit.mn

2024.01.25 № 157


ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЛХАМСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Шарын гол сумын ТЕЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шарын гол сумын ТЕЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт өмнөх оноос 2 дахин өсөж, гүйцэтгэлээр 1,655.1 сая төгрөг буюу 86.8 хувиар зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хэлсийг шинэчлэн тогтоож, төрийн захиргааны албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдлийг 20-100 хувиар тооцож олгосноор цалингийн зардал өмнөх оноос 27.2 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Шарын гол сумын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Шарын гол сумын ИТХ-аар хэлэлцээд, 96.5 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,069,474.5 | 1,305,702.8 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 598,153.8 | 716,907.8 |
| 33 | АВЛАГА | 243,130.5 | 310,259.7 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 192,727.7 | 235,377.8 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 35,462.5 | 43,157.5 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 2,906,178.2 | 3,779,192.9 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,906,178.2 | 3,779,192.9 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,901,760.2 | 3,234,602.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 4,418.0 | 6,011.0 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 0.0 | 538,579.1 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 3,975,652.7 | 5,084,895.7 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 13,883.9 | 68,498.7 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 13,883.9 | 68,498.7 |
| 41300 | Өглөг | 13,883.9 | 68,498.7 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 3,961,768.8 | 5,016,397.0 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,961,768.8 | 5,016,397.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,033,665.2 | 1,033,665.2 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,082,484.5 | 3,137,112.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 845,619.1 | 845,619.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 3,975,652.7 | 5,084,895.7 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 4,462,332.1 | 4,819,527.6 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 1,665,327.5 | 2,162,990.5 |
| 110 | Орлогын албан татвар | 1,400,227.6 | 1,910,707.1 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,400,227.6 | 1,910,707.1 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 98,353.5 | 72,308.9 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 166,746.3 | 179,974.4 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1,008,687.5 | 58,049.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,008,687.5 | 58,049.3 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,788,317.1** | **2,598,487.8** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,781,968.2** | **3,338,292.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,781,968.2** | **3,338,292.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,722,906.4** | **3,319,294.1** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 745,281.3 | 989,668.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 93,365.8 | 124,126.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,267,083.8 | 157,543.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 113,821.3 | 93,006.0 |
| 2105 | Нормативт зардал | 51,572.7 | 60,053.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 141,158.8 | 33,999.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,911.2 | 4,406.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 23,867.4 | 41,243.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 282,844.2 | 1,815,247.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 59,061.8 | 18,998.6 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 1,680,363.9 | 1,481,234.9 |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 18,478,848.2 | 426,606.7 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | (16,798,484.4) | 1,054,628.2 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 3,733,772.4 | 4,931,368.0 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 1,665,327.5 | 2,162,990.5 |
| 110 | Орлогын албан татвар | 1,400,227.6 | 1,910,707.1 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,400,227.6 | 1,910,707.1 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 98,353.5 | 72,308.9 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 166,746.3 | 179,974.4 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 12,360.7 | 14,741.4 |
| 1181 | Газрын төлбөр | 154,128.5 | 165,233.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 257.1 | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 280,127.8 | 169,789.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 280,127.8 | 169,789.7 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,788,317.1 | 2,598,587.8 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,527,500.8 | 2,896,972.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,527,500.8 | 2,896,972.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,461,051.5 | 2,877,326.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 755,018.4 | 988,524.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,523.4 | 123,632.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,267,083.8 | 112,735.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 64,506.0 | 77,847.9 |
| 2105 | Нормативт зардал | 57,881.1 | 75,347.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 131,600.3 | 61,156.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,953.2 | 4,406.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,027.4 | 39,127.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,457.8 | 1,394,547.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 66,449.3 | 19,646.6 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 1,206,271.6 | 2,034,395.2 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 945,361.6 | 1,710,701.2 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 945,361.6 | 1,710,701.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 945,361.6 | 1,710,701.2 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (945,361.6) | (1,710,701.2) |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | (30,000.0) | (204,940.0) |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 30,000.0 | 204,940.0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 230,910.0 | 118,754.0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 367,243.7 | 598,153.8 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 598,153.8 | 716,907.8 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,268,447.2** | **15,183,969.3** | **2,746,562.9** | **21,198,979.4** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (2,234,782.0) | (14,325,451.9) | 16,134,405.9 | (425,828.0) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,033,665.2** | **858,517.4** | **18,880,968.8** | **20,773,151.4** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | **3,268,447.2** | **15,183,969.3** | **2,746,562.9** | **21,198,979.4** |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| C06 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | (16,798,484.4) | (16,798,484.4) |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,033,665.2** | **845,619.2** | **2,082,484.4** | **3,961,768.8** |
| D01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **1,033,665.2** | **845,619.2** | **2,082,484.4** | **3,961,768.8** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,033,665.2** | **845,619.2** | **2,082,484.4** | **3,961,768.8** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 1,054,628.2 | 1,054,628.2 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,033,665.2** | **845,619.2** | **3,137,112.6** | **5,016,397.0** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,795,580.0 | 4,285,111.8 | (510,468.2) | 89.4 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,603,018.7 | 2,425,090.9 | (177,927.8) | 93.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,577,226.2 | 2,408,478.3 | (168,747.9) | 93.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 824,442.8 | 748,378.2 | (76,064.6) | 90.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 103,055.3 | 93,749.8 | (9,305.5) | 91.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,353,162.0 | 1,290,378.4 | (62,783.6) | 95.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 47,198.7 | 46,652.2 | (546.5) | 98.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 152,608.9 | 145,504.5 | (7,104.4) | 95.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,165.2 | 4,158.0 | (1,007.2) | 80.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,221.7 | 33,525.5 | (6,696.2) | 83.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,371.6 | 46,131.7 | (5,239.9) | 89.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 25,792.5 | 16,612.6 | (9,179.9) | 64.4 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 20,863.5 | 13,476.0 | (7,387.5) | 64.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,929.0 | 3,136.6 | (1,792.4) | 63.6 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 1,898,134.0 | 1,655,080.9 | (243,053.1) | 87.2 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 294,427.3 | 204,940.0 | (89,487.3) | 69.6 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,795,580.0 | 4,237,319.8 | (558,260.3) | 88.4 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,804,387.5 | 1,661,758.7 | (142,628.8) | 92.1 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,414,166.8 | 2,416,643.2 | 2,476.4 | 100.1 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 577,025.7 | 158,917.9 | (418,107.8) | 27.5 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 212,406.1 | 212,406.1 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 164,614.1 | 164,614.1 | 0.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **54,726.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **54,726.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **50,322.2** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,248.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,846.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,479.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,747.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,403.9** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,094.0 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,309.9 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **54,726.1** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **54,726.1** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,430.6 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,295.5 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 179.4 сая төгрөгийн зөрчил[1] илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлэв.

**3.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

**3.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. ИТХ-ын баталсан тогтоолтой холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт:

Тус сумын ИТХ-ын тогтоолоор 2023 оны төсвийг батлахдаа ХХС-ийн эхний үлдэгдлийг тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*"; 6 дугаар зүйлийн 6.2.2-т "*жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх*"; 65 дугаар зүйлийн 65.1.1-д "*тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т , 6 дугаар зүйлийн 6.2.2, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг баримталж, сумын ИТХ-ын тогтоолоор төсөв батлахдаа төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн батлах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 106.6 | 1 | 106.6 | - | - | 1 | 106.6 | - | - | - | - |
| "Тулга сувилал" ОНӨААТҮГ | 1 | 481.5 | | | 1 | 481.5 | 1 | 481.5 | | | | |
| **Дүн** | **2** | **588.1** | **1** | **106.6** | **1** | **481.5** | **2** | **588.1** | **-** | **-** | **-** | **-** |

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] *Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.*

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 3 | 25.2 | - | - | 1 | - | 2 | 25.2 | - | - | - | - |
| ИТХ | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| ХХС | 1 | 4.1 | - | - | - | - | 1 | 4.1 | - | - | - | - |
| “Тулга сувилал” ОНӨААТҮГ | 2 | 3.2 | 1 | 2.4 | - | - | 1 | 0.8 | - | - | - | - |
| ТЕЗ | 1 | 179.4 | | | | | 1 | 179.4 | | | | |
| **Дүн** | **8** | **211.9** | **1** | **2.4** | 1 | - | **6** | **209.5** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ТЕЗ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| ЗДТГ | 1 | 43.2 | | | | | 1 | 43.2 |
| ИТХ | 1 | 88.5 | - | - | - | - | 1 | 88.5 |
| **Дүн** | **3** | **131.7** | **-** | **-** | **-** | **-** | **3** | **131.7** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | - | - | - | - | | |
| **Дүн** | | | - | - | - | - | | |
| **Нийт дүн** | **3** | **131.7** | **-** | **-** | **-** | **-** | **3** | **131.7** |

**Долоо. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 4 | 3 | 1 | | 3 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ОНӨҮГ | 1 | 1 | | | | 1 | | |
| 5 | ТЕЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **6** | **5** | **1** | | **4** | **1** | | |